- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэдээ тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гарган ирүүлнэ.
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй, үр ашигтай байдлыг хангах, Орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх.
- Сумын Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, газрын харилцаа, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хууль, тогтоол шийдвэр, хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээ, бодлогын зорилтууд шаардлагын түвшинд хэрэгжиж, үйл ажиллагаа, иргэдэд үйлчлэх нийтийн үйлчилгээний хүрээ

дээшилсэн байна гэх мэт нийт 6 бодлогын хүрээнд 144 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин

- Алсын хараа-2050
- Шинэ сэргээлтийн бодлого
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллага, сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,344.1 сая төгрөгөөр буюу 10.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Мөнгөн хөрөнгө	360.2	419.7	59.5	16.5
Авлага	78.5	55.4	(23.1)	(29.4)
Бараа материал	52.1	127.8	75.7	145.3
Үндсэн хөрөнгө	3,917.6	4,076.1	158.5	4.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,414.6</b>	<b>4,684.4</b>	<b>269.8</b>	<b>6.1</b>
Өр төлбөр	11.3	2.0	(9.3)	(82.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,403.3	4,682.4	279.1	6.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,414.6</b>	<b>4,684.4</b>	<b>269.8</b>	<b>6.1</b>

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад авлага, бараа материалын дансны эцсийн үлдэгдлүүдэд материаллаг өөрчлөлтүүд гарсан бөгөөд тайлант онд Хоршоо хөгжүүлэх

сангаас зээл олгосон, сумын ЗДТГ-т үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн бараа материалын өсөлтүүд тус тус нөлөөлсөн байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 419.7 сая төгрөг болж, өмнөх оноос 59.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	360.2	419.7	59.5
<b>Төгрөг</b>	<b>360.2</b>	<b>419.7</b>	<b>59.5</b>
Төрийн сангийн харилцах	360.2	419.7	59.5
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
<b>Дүн</b>	<b>360.2</b>	<b>419.7</b>	<b>59.5</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны өөрчлөлтөд: Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 38.0 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 16.2 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.8 сая төгрөгөөр, нэмэлт дансны төвлөрүүлэлтийн үлдэгдэл 7.3 сая төгрөгөөр, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахмадын сан 1.7 сая төгрөгөөр нэмэгдэж, Засаг даргын Тамгын газрын ахмадын сангийн үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн ба эцсийн үлдэгдэл 419.7 сая төгрөг нь холбогдох байгууллагуудын төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

#### Аудитын илрүүлэлт:

**ИТХ:** - Тайлант хугацаанд 4,390,000 төгрөгийн бэлэн мөнгөний ажил гүйлгээг мөнгөн кассын дансаар дамжуулахгүй шууд өглөгийн дансанд бүртгэснийг залруулсан.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 55.4 сая төгрөг болж, өмнөх оноос 23.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	8.9	0.5	(8.4)
Зээлийн авлага	69.6	54.9	(14.7)
<b>Дүн</b>	<b>78.5</b>	<b>55.4</b>	<b>(23.1)</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Сум хөгжлийн сангаас 40.0 сая төгрөгийн зээл олгож, Эргэн төлөлтөөр 3 зээлдэгч зээлээ хаасан байна. Жилийн эцэст авлага дансны өөрчлөлтөд 54.9 сая төгрөг болж 14.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

**ХХС:** - Авлагын эхний үлдэгдлийг 1,691.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 67.0 сая төгрөг болж, өмнөх оноос 29.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>0.6</b>	<b>0.6</b>	-
Тусгай зориулалттай материал	0.6	0.6	-
<b>Хангамжийн материал</b>	<b>30.9</b>	<b>61.1</b>	30.2
Бичиг хэргийн материал	2.6	3.3	0.7
Аж ахуйн материал	21.1	50.5	29.4
Сэлбэг хэрэгсэл	1.0	0.7	(0.3)
Түлш, шатах тослох материал	6.2	6.5	0.3
<b>Мал амьтад</b>	<b>6.2</b>	<b>5.3</b>	<b>(0.9)</b>
<b>Дүн</b>	<b>37.6</b>	<b>67.0</b>	<b>29.3</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны өөрчлөлтөд: сумын ЗДТГ-ын үлдэгдэл 29.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Энэ нь тайлант онд тухайн байгууллагад үнэ төлбөргүйгээр 27.0 сая төгрөгийн материал нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

**ЗДТГ:** - Байгууллагад бүртгэлтэй малыг нас дэвшүүлэхдээ буруу дансны бичилтийг гүйцэтгэсний улмаас 4,540.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг заруулсан.

#### 3.4.4 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 66.2 сая төгрөг болж 45.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь өвс тэжээлийн нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

#### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,076.2 сая төгрөг болж, өмнөх оноос 158.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>3,829.9</b>	<b>3,989.2</b>	<b>159.4</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,752.2	1,752.2	-
Авто-тээврийн хэрэгсэл	340.5	520.5	180.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	434.4	466.9	32.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	34.7	81.4	46.7
Бусад үндсэн хөрөнгө	2,045.7	2,196.3	150.6
Дуусаагүй барилга, байгууламж	-	134.4	134.4
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>87.8</b>	<b>86.9</b>	<b>(0.8)</b>
Программ хангамж	2.8	2.8	-
Бусад биет бус хөрөнгө	85.9	85.9	-
<b>Дүн</b>	<b>3,917.6</b>	<b>4,076.2</b>	<b>158.5</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлтөд ЗДТГ-ын хөрөнгө 401.5 сая төгрөгөөр, ИТХ-ын хөрөнгө 8.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, ОНХС-ийн дансанд 134.4 сая төгрөгийн дуусаагүй барилгын дүнгээр нэмэгдэж, 385.6 сая төгрөгийн элэгдэл хорогдол тооцсон дүнгээр буурчээ. Тайлант онд сумын ЗДТГ нь үнэ төлбөргүйгээр нийлүүлэгдсэн 134.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэн авсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

**ЗДТГ:** - Төсвийн хөрөнгөөр шинээр бэлтгэсэн 96,961.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ ашиглах жил оруулаагүйн улмаас тайлант хугацааны 5,115.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоолоогүй байсныг заруулсан.

**ИТХ:** - Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс шүүж үзэхэд үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,003,618 төгрөгөөр дутуу, хуримтлагдсан элэгдэл 99,972.96 төгрөгөөр илүү тайлагнагдсан байсныг залруулсан.

**ОНХС:** - Тайлант хугацаанд хэрэгжүүлж дууссан 52.0 сая төгрөгийн 1 ТАХ-г холбогдох байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэж тайлагнаагүй, хэрэгжиж дуусаагүй 134.4 сая төгрөгийн 1 ТАХ-ний санхүүжилтийг дуусаагүй барилга дансанд бүртгээгүй байсныг залруулсан.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2.0 сая төгрөг болж, өмнөх оноос 9.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>11.3</b>	<b>2.0</b>	<b>(9.3)</b>
Байгууллагад төлөх өглөг	9.0	0.4	(8.6)
Хувь хүмүүст төлөх өглөг	2.2	1.6	(0.6)
<b>Дүн</b>	<b>11.3</b>	<b>2.0</b>	<b>(9.3)</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: ХХсангийн зээлдэгчийн илүү төлсөн 1.5 сая төгрөгийг өглөгтэй. ЗДТГазар 0.3 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг нэмэгдэж, өмнөх оны нэмэлт дансны үлдэгдэл төвлөрүүлэлтийн өглөг 7.1 сая төгрөгөөр буурсан зэрэгтэй холбоотой байна.

### Аудитын илрүүлэлт:

**ИТХ:** - Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 144,000 төгрөг, хувь хүний орлогын албан татварын авлага 408,851.80 төгрөгийг тус тус санхүүгийн тайланд авлага өглөгөөр тусгаагүйг залруулсан.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,682.4 сая төгрөг болж, өмнөх оноос 279.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	704.0	704.0	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,933.5</b>	<b>3,212.6</b>	<b>279.1</b>
Өмнөх үеийн үр дүн	5,843.9	2,933.5	(2,910.4)
Тайлант үеийн үр дүн	(2,910.3)	279.1	3,189.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	765.7	765.7	-
<b>Дүн</b>	<b>4,403.3</b>	<b>4,682.4</b>	<b>279.1</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: ЗДТГ-ын тайлант үеийн үр дүн 108.8 сая төгрөгөөр, СХС, НСС-ийн үр дүн 4.2 сая төгрөгөөр, ОНХС-ын тайлант үеийн үр дүнгийн 173.6 сая төгрөгийн тус тус нэмэгдэж, ИТХ-ын үр дүн 7.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Эдгээр өөрчлөлтөд үнэ төлбөргүйгээр үндсэн хөрөнгө, бараа материалын нэмэгдэл болон үйл ажиллагааны зардлын зарцуулалт бага зэрэг нөлөөлсөн байна.

### Аудитын илрүүлэлт:

**ЗДТГ:** - Орлого, үр дүнгийн тайланд нийт 6,716.8 мянган төгрөгийн зардлыг буруу ангилалд бүртгэснийг залруулсан.

- Цалингийн зардлын тайлагналыг шалгахад үйлдвэрчний эвлэлд 109.9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд авлага тусгаагүйг залруулсан.

**ИТХ:** - Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланг алдаатай илэрхийлж нийт 14.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

**ОНХС:** - тайлант хугацааны нийт 142.4 сая төгрөгийн санхүүжилтийг үр дүнгийн тайланд алдаатай тайлагнасныг залруулсан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,002.3 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5.0 сая төгрөг, нийт зарлагыг 1,007.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгаас 2023 оны төсвийн 577.1 сая төгрөгөөр буюу 430.2 сая төгрөгөөр бууруулан хянаж хүргүүлсэн байна. Үүнээс татварын болон татварын бус орлогыг 474.2 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгаас хянаж ирүүлсэн төслийг 111.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 585.4 сая төгрөгөөр, харьяа төсөвт байгууллагуудын зардлыг 688.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

#### 3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2023 оны орон нутгийн төсөв батлах тухай 2022 оны 10/06 дугаар тогтоолоор Улаанбадрах суманд 176.1 сая төгрөгөөр санхүүгийн дэмжлэгийг олгохоор батлан, аймгийн ИТХ-ын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 12/05 дугаар тогтоолоор санхүүгийн дэмжлэгийг 176.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 353.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор тодотгон баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 17/15 дугаар тогтоолоор сумын татварын болон татварын бус орлогыг 203.2 сая төгрөгөөр төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 488.1 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 32.8 сая төгрөгөөр давсан байна. Гүйцэтгэл 107.2 хувиар биелсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/ сая төгрөг /

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /дутуу +, илүү - /	Хувь
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	161.8	232.2	70.4	143.5
2	Үйл ажиллагааны орлогын татвар	11.5	3.0	(8.5)	26.0
3	Хувь хүнээс суутгасан ОАТ	7.3	7.6	0.3	82.2
4	Хадгаламж хүү	20.7	21.1	0.4	101.9
5	Хөрөнгө борлуулсны орлого	3.4	3.3	(0.1)	97.0
6	Бууны татвар	2.5	1.9	(0.6)	76.0
7	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	3.5	3.3	(0.2)	94.3
8	Малын тоо толгойн албан татвар	67.8	51.4	(16.4)	75.8
9	УТХураамж	0.9	0.8	(0.1)	88.9
10	Газрын төлбөр	176.0	159.7	(16.3)	90.7
11	Хог хаягдлын хураамж	3.9	6.3	2.4	161.5

Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТТАМАТөлбөр	0.3	0.2	(0.1)	66.7
13	Хүү торгуулийн орлого	3.0	2.5	(0.5)	83.3
	<b>Нийт</b>	<b>455.3</b>	<b>488.1</b>	<b>32.8</b>	<b>107.2</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 6 нэр төрлийн орлого 73.8 сая төгрөгөөр давж, 7 нэр төрлийн орлого 42.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлого төлөвлөсөн дүнгээс 70.4 сая төгрөгөөр давсан нь албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй,
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 0.3 сая төгрөгөөр давсан нь иргэний орлогоос суутгасан татвартай холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 0.4 сая төгрөгөөр давсан нь хадгаламж эзэмшигчдийн тоо нэмэгдсэнтэй, Хадгаламжийн хүү өссөнтэй холбоотой
- Хог хаягдлын төлбөр 2.4 сая төгрөгөөр давсан нь татварын дутуу төлөлттэй ААН-үүд өрөө төлж барагдуулсантай тус тус холбоотой байна.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн дүнгээс 8.5 сая төгрөгөөр давсан нь жилийн эцэст ноосны урамшуулал орсонтой,
- Хөрөнгө борлуулсны орлого 0.1 сая төгрөгөөр давсан нь татвар төлөгчид үл хөдлөх эд хөрөнгөө худалдан борлуулсантай,
- Малын тоо толгойн албан татварын орлого 16.4 сая төгрөгөөр тасарсан нь байгалийн цаг уур хүндэрч зуншлага муу, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой малчид татвараа дутуу төлсөнтэй,
- Газрын төлбөрийн орлого 16.3 сая төгрөгөөр давсан нь өмнө оны дутуу төлөлт хийгдсэнтэй,
- Хүү торгуулийн орлого 0.5 сая төгрөгөөр тасарсан нь торгууль оногдуулах арга хэмжээ үүсээгүйтэй холбоотой.
- Галт зэвсгийн татвар 0.6 сая төгрөгөөр буурсан нь бүртгэлтэй байсан буу хурагдсан учир татвар төлөгч төвлөрүүлээгүй
- Үл хөдлөх хөрөнгийн орлого 0.2 сая төгрөгөөр тасарсан нь татвар төлөгч хөрөнгө борлуулаагүй учир,

### 3.5.3 Төсвийн гүйцэтгэл

1. Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 зорилтод хөтөлбөрт зориулан сумын ИТХ-ын 2022 оны 11/26 дугаар тогтоолоор 1,552.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 790.2 сая төгрөгийг урсгал зардалд, 762.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 176.1 сая төгрөгийг аймгаас авах татаас санхүүжилтээс, 442.5 сая төгрөгийг сумын татварын болон татварын бус орлогоос, 37.5 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 656.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 59.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,552.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд төсөвт нэг удаа тодотгол хийсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 13/04 дүгээр тогтоолоор 258.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг 1,810.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгаас авах татаас санхүүжилтийг 176.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 353.0 сая төгрөгөөр, сумын татварын болон татварын бус орлогыг 18.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 461.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын татварын болон татварын бус орлого 490.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 375.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 60.9 сая төгрөг, аймгаас авсан татаас санхүүжилт 250.7 сая төгрөг, нийт 1,177.3 сая төгрөгийг бүрдүүлэн, орлогын биелэлт 107.2 хувьтай байна.

Сумын татварын болон татварын бус орлого 490.2 сая төгрөгөөс орон нутгийн төсөвт байгууллагуудад 438.8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн санд 51.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөгөөр/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /дутуу +, илүү - /	Хувь
1	Сумын татварын болон татварын бус орлого	461.3	490.2	28.9	106.2
2	Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг	353.0	250.7	(102.3)	71.0
4	Үйл ажиллагааны орлого	55.5	60.9	5.4	109.7
5	ОНХС, ТАТөсөл	656.9	375.5	281.4	57.2
6	Өмнөх оны үлдэгдлээс	352.7	352.7	0	-
	<b>Дүн</b>	<b>1,879.4</b>	<b>1,530.0</b>	<b>349.4</b>	<b>81.4</b>

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 689.5 сая төгрөг буюу 81.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 32.7 сая төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 24.1 сая, Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын төсвийг 0,1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	624.8	592.1	32.7	94.8
2	Баг, хорооны ҮАЗардал	74.4	50.3	24.1	67.6
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.4	0.4	0.0	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	7.4	7.3	0.1	98.6
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	25.0	25.0	0.0	100
6	Хур хог хаягдал, орчны бохирдол	3.5	3.5	0.0	100
7	Улсын их баяр наадам	5.0	5.0	-	100
8	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	3.9	3.9	0	100
9	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	2.0	2.0	0.0	100
	<b>Дүн</b>	<b>746.4</b>	<b>689.5</b>	<b>56.9</b>	<b>92.3</b>

Харьяа төсөвт байгууллага, сангуудын зардлын гүйцэтгэлээр авч үзэхэд сумын ЗДТГ 54.7 сая төгрөгөөр, ИТХ 2.2 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу зарцуулсан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

**ЗДТГ:** - Тайлант онд төрийн албан хаагчдын сургалтын үеэр төсвийн хөрөнгөөр 190.0 мянган төгрөгийн азын сугалаа зохион байгуулж, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

- Тайлант онд цалингийн зардлаас 2,745.9 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.

**ИТХ:** - Сумын ИТХ-ын 2023.07.07 өдрийн 13/04 дүгээр тогтоолоор ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн төсвийг 5,000,000 төгрөгөөр баталж, 4,998,800 төгрөгийг зарцуулсанд албанд шаардлага хүргүүлсэн.

- Гурван албан хаагчид 600,000 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, орлогыг шимтгэлийн тайланд тайлагнаагүй албан шаардлага хүргүүлсэн.

**ОНХС:** - Мөнгөн гүйлгээний тайлангийн зарлагыг 1.2 сая төгрөгөөр илүү тайлагнасныг зарцуулсан.

**ХХС:** - Зээлийн эргэн төлөлтийн орлогыг 265.2 мянган төгрөгөөр дутуу тусгасныг зарцуулсан.

2. Аймгийн ИТХ-ын 2023 оны төсөв баталсан 2022 оны 10/06 дугаар тогтоолоор Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Соёлын байгууллагуудын үйлчилгээ ашиглалтын зардлын төсвийг 283.8 сая төгрөгөөр аймгийн төсвөөс олгохоор баталж, аймгийн ИТХ-ын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан 2023 оны 12/05 дугаар тогтоолоор төсвийг өөрчлөлтгүй 283.8 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 11. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын санхүүжилтийн хуваарилалт, төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөгөөр/

№	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ЭМТөв	29.9	24.9	5.0	83.3
2	Сургууль	107.0	101.2	5.8	94.5
3	Цэцэрлэг	36.5	35.4	1.1	96.9
4	Соёл	110.4	103.6	6.8	93.8
	<b>Дүн</b>	<b>283.8</b>	<b>265.1</b>	<b>18.7</b>	<b>93.4</b>

Гүйцэтгэлээр 265.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, тогтмол зардалд 256.6 сая төгрөгийг, урсгал засварын зардалд 8.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3. Аймгийн болон Сумын ИТХ-аар сумын орлого, зардлын нийт төсвийг 1,756.5 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,756.6 сая төгрөг буюу 82.3 хувийн биелэлттэй бөгөөд, үүний 461.3 сая төгрөг нь сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого, 353.0 сая төгрөг нь аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, 670.4 сая төгрөг нь аймгаас олгосон ОНХС-ын санхүүжилт, 283.8 сая төгрөг нь улсын төсөвт байгууллагуудын байр ашиглалтын зардлын санхүүжилт, 61.5 сая төгрөг нь төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагааны орлого байна. Сангуудын оны эхний үлдэгдлээс 239.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн орлогыг орон нутгийн төсөвт байгууллагуудад 800.1 сая төгрөгийг, улсын төсөвт байгууллагуудад 404.4 сая төгрөгийг, ОНХС-д 708.6 сая төгрөгийг, СХС болон НСС-д 42.9 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Нийт зардал 2,195.0 сая төгрөг буюу 86.1 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд цалин, НДШ-ийн зардал 575.2 сая төгрөг буюу 26.2 хувийг, тогтмол зардал 427.7 сая төгрөг буюу 19.5 хувийг, ОНХС-ын зардал 766.5 сая төгрөг буюу 34.5 хувийг, бусад зардал 425.6 сая төгрөг буюу 19.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Төсвийн нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төсвийн зардлын гүйцэтгэл			
		Батлагдсан төсөв	Зардлын гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	ЗДТГазар	629.7	568.9	60.8	90.3
2	ИТХ	122.7	120.5	2.2	98.2
3	ОНХС	817.2	426.9	390.3	52.2
4	СХС	232.4	42.1	190.3	18.1
5	НСС	8.5	0.9	7.6	10.5
6	ЭМТөв	29.9	24.9	5.0	83.3
7	Сургууль	107.0	101.2	5.8	94.5
8	Цэцэрлэг	36.5	35.4	1.1	96.9
9	Соёл	110.4	103.6	6.8	93.8
	<b>Дүн</b>	<b>2,375.6</b>	<b>2,195.0</b>	<b>180.6</b>	<b>92.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн үр ашигтай захиран зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Ариунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/56 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 4,407.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 44.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 35.3 сая төгрөгөөр тогтоосон.

##### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. Харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

##### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

###### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### **Аудитын илрүүлэлт:**

**ЗДТГ:** -Шилэн дансны цахим системд худалдан авах ажиллагааны мэдээлэл, 291.1 сая төгрөгийн 19 орлогын гүйлгээ, 158.8 сая төгрөгийн 7 зарлагын гүйлгээ, 29.8 сая төгрөгийн 11 шийдвэрийг байршуулаагүйг нөхөн байршуулах зөвлөмж хүргүүлсэн.

**ИТХ:** - Шилэн дансанд хөрөнгө зарцуулах 8,905,800 төгрөгийн 18 тушаал, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 2 орлого 24,546,900 төгрөгийг хугацаа хоцроож байршуулсанд зөвлөмж хүргүүлсэн.

#### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгсөн ба хэрэгжилтийг ирүүлсэн байна.

#### **4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад  
талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг даргын тамгын газар	4	16.5	2	5.2	2	11.3	4	16.5	-	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4	20.3	1	0.6	3	19.7	4	20.3	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сан	3	331.3	1	186.4	2	144.9	3	331.3				
Хоршоо хөгжүүлэх сан	2	2.0	-	-	2	2.0	2	2.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>370.1</b>	<b>4</b>	<b>192.2</b>	<b>9</b>	<b>177.9</b>	<b>13</b>	<b>370.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	2	2.9	1	0.2	1	2.7	-	-	-	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	5.7	-	-	2	5.7	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>8.6</b>	<b>1</b>	<b>0.2</b>	<b>3</b>	<b>8.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг даргын тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>